



**YAG**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

### Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараахь  
хаягаар харилцана уу:

Газрын дарга: С.Энхзаяа  
Утас: 261663  
Цахим хаяг: [enkhzayas@audit.gov.mn](mailto:enkhzayas@audit.gov.mn)

Орон нутгийн аудитын албаны менежер:  
Л.Одгэрэл  
Утас: 260512  
Цахим хаяг: [odgerell@audit.gov.mn](mailto:odgerell@audit.gov.mn)

Аудитор: Д.Уртнасан  
Утас: 261628  
Цахим хаяг: [urtnasand@audit.gov.mn](mailto:urtnasand@audit.gov.mn)

Үндэсний аудитын газар  
Засгийн газрын IV байр  
Бага тойруу-6 Улаанбаатар-46 Монгол Улс  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

#### АГУУЛГА

Оршил  
Санхүүгийн дотоод хяналт  
Илрүүлсэн гол зүйлс ба шийдлүүд  
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт  
Аудитын санал дүгнэлт

**Хавсралт 1:** Аудитын гэрчилгээ

**Хавсралт 2:** Менежментийн захидал

**Хавсралт 3:** Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

**Хавсралт 4:** Аудит хийгдсэн төсвийн  
гүйцэтгэлийн тайлан

## Оршил

Улсын Ерөнхий прокурорын төсвийн багцын 2013 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүнг танилцуулж байна. Менежментийн захидалд санхүүгийн зарим үйл ажиллагааг сайжруулахаар өгсөн зөвлөмж, түүний хариуг тусгасан болно.

Тус төсвийн багцын Санхүүгийн байдлын тайланд 2013 оны эцэст 976.2 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 19,660.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэйгээр тус тус толилуулсан байна.

Улсын Ерөнхий прокурорын төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайланд 43 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдэн аудитад хамрагдсан байна.

Нийт төсвийн 10 хувьд Үндэсний аудитын газар, 90 хувьд Аймаг, нийслэлийн аудитын газрууд тус тус аудит хийж, Дорнод аймгийн Прокурорын газар, Нийслэлийн Прокурорын газарт “Хязгаарлалттай” санал дүгнэлт, бусад газруудад буюу төсвийн багцын 96 хувьд нь “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

### Санхүүгийн дотоод хяналтын үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Ийнхүү дахин хянахдаа Улсын Ерөнхий прокурорын газрын хэрэгжүүлдэг хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаарх өөрийн мэдээллийн сантай харьцуулан шинжилгээ хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон.

Улсын Ерөнхий прокурорын газрын дотоод аудиторын 2013 онд хийсэн ажлын тайлантай танилцаж, санал солилцсон.

УЕПГ-ын дотоод аудитор 5 аймгийн Прокурорын газарт аудит хийж, Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоожээ.

Мөн Аймаг, нийслэл, тээвэр, дүүрэг, сум дундын прокуроруудын тушаалын хууль зүйн үндэслэлтэй танилцаж, тушаалын алдааг залруулахаар 11 зөвлөмж өгсөн байна.

### Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд

Улсын Ерөнхий прокурорын байгууллагуудад ҮАГ, аймаг, нийслэлийн Аудитын газруудын хийсэн аудитаар илэрсэн зарим асуудлыг дараах байдлаар хураангуйлан тэмдэглэв.

**Нэг. Орон нутаг дахь харьяа байгууллагуудад хийсэн аудитаар илэрсэн зарим асуудлууд**

#### **1.1 Төсвийн хөрөнгийн зарцуулалт, түүнд тавих хяналтын талаар**

- *Дорнод аймгийн Прокурорын газар* тавилга, эд хогшлын зардлаас батлагдсан төсвөөс 6.0 сая төгрөгийг зориулалт бусаар, мөн Төсвөөс туслах аж ахуйн зардалд 3.0 сая төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-д “Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн,

- *Баянхонгор аймгийн Прокурорын газар* 2013 оны 12-р сард олгосон урамшуулалт цалингаас ХХОАТ, НДШ-д 0.8 сая төгрөгийг дутуу суутгасан,
- *Говь-Алтай аймгийн Прокурорын газар* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.1, 7.7, 19.1.4 заалтуудыг зөрчиж анхан шатны баримтгүйгээр Шунхлай трейдинг ХХК-д шатахууны үнэ 2.3 сая төгрөгийг шилжүүлсэн, дотоод албан томилолтоор ажиллаагүй байхад Аэро Монголия ХХК руу 0.7 сая төгрөгийг шилжүүлсэн, авлагаар тайлагнаагүй, үндсэн цалин болон амралтын цалинг давхардуулан 0.2 сая төгрөгийг олгосон, төсвийн гүйцэтгэлийг бүлгийн дүнгээр тооцож үзэхэд Төсвийн тухай хуулийн 6.4.1 заалтыг зөрчиж зарим зардлыг 2.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

## **1.2 Бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл, ангилал, худалдан авалтын талаар**

- *Сүхбаатар аймгийн Прокурорын газар* гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 0.9 сая төгрөгөөр компьютер худалдан авч төсвийг зориулалт бус зарцуулсан,
- *Говьсүмбэр аймгийн Прокурорын газарт* УЕПГ-аас санхүүгийн тайлан тэнцэл гарсны дараа 2014 оны тушаалаар үндсэн хөрөнгө, бараа материал орлогоор бүртгүүлж, 2013 оны тайлан тэнцэлд тусгуулсан, мөн 1.7 сая төгрөгийн бараа материалыг бүрэн хүлээлгэж өгөөгүй байна.
- *Архангай аймгийн Прокурорын газар* гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 1.7 сая төгрөгөөр зөвшөөрөлгүйгээр үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## **Хоёр. Нийслэлийн Прокурорын харьяа байгууллагуудад хийсэн аудитаар илэрсэн зарим асуудлууд**

### **2.1 Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ажил гүйлгээ хийжээ**

- Нийслэлийн Прокурорын газар 32.9 сая төгрөгийн, Баянгол дүүргийн Прокурорын газар 25.6 сая төгрөгийн бараа материалын анхан шатны баримтын бүрдэлгүй, гарын үсэггүй баримтаар ажил гүйлгээ хийсэн байна.

### **2.2 Санхүүгийн тайланд ажил гүйлгээг бүрэн илэрхийлээгүй байна**

- Нийслэлийн Прокурорын газар Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаал “Төсвийн байгуулагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, 32 дугаар тушаал “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэмдэглэлийг бэлтгэх аргачлал”, 2013 оны 269 тоот тушаал “Журамд өөрчлөлт оруулах тухай” зааврын холбогдох заалтуудыг хэрэгжүүлээгүйгээс санхүүгийн байдлын тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 61.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 3.9 сая төгрөгийн бараа материал нийт 65.9 сая төгрөгөөр Засгийн газрын сан дансыг нэмэгдүүлэн санхүүгийн тайланг буруу нэгтгэн тайлагнасан.
- Баянзүрх дүүргийн Прокурорын газар 7.0 сая, Сүхбаатар дүүргийн Прокурорын газар 35.0 сая, Чингэлтэй дүүргийн Прокурорын газар 19.8 сая төгрөгийн үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгөө Засгийн газрын сан дансыг нэмэгдүүлэн буруу илэрхийлсэн,

- Нийслэлийн Прокурорын газар үнэ төлбөргүй авсан 150.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үр дүнгийн тайланд орлогоор бүртгээгүй, хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмжийн 7.9 сая төгрөгийг тайланд тусгаагүй, үндсэн хөрөнгө данснаас хассаны 1.3 сая төгрөгийн гарзыг бүртгээгүй, үнэ төлбөргүй хүлээн авсан 61.9 сая төгрөгийн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд Засгийн газрын сан дансыг нэмэгдүүлэн буруу нэгтгэсэн, үнэ төлбөргүй хүлээн авсан 84.3 сая төгрөгийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын санхүүжилтээр тус тус зөрүүтэй илэрхийлсэн байна. /Эдгээр алдааг аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн./
- Чингэлтэй дүүргийн Прокурорын газар 6.5 сая, Сүхбаатар дүүргийн Прокурорын газар 9.5 сая төгрөгийн бараа материалын тайлан гаргаагүй байна.
- Баянзүрх дүүргийн Прокурорын газар, Эрүүгийн хэргийн архивын нягтлан бодогч ажилтнуудын өөрсдийнх нь хүсэлтээр 27.4 сая төгрөгийн 10 ажилтны цалинг(тухайн ажилтны картны хугацаа дууссан, картгүй гэдэг нэрээр) өөрийн байгууллагын бусад ажилтнуудын дансаар дамжуулан, мөн 2 ажилтны тэтгэмжийн 6.8 сая төгрөгийг өөрийн дансаар дамжуулан гүйлгээ хийж, НББ-ийн тухай хуулийн 20.1.2-т “өөрийн ажил, үүргийн дагуу шууд хяналт тавьдаг албан тушаалын ажлыг хавсран гүйцэтгэх; “ гэсэн заалтыг зөрчжээ.
- УЕПГ-ын Тамгын газрын 2013 оны Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд худалдаж авсан 163.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Програм хангамж гэж буруу илэрхийлсэн, 2 аж ахуйн нэгж байгууллагад өгөх өглөг 390.1 сая төгрөгийг санхүүгийн байдлын тайланд тусгаагүй байна.

Улсын Ерөнхий прокурорын төсвийн багцын 2013 оны Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт 1,817.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 839.8 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 5.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоон, 972.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 31 зөвлөмж өгсөн байна.

### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

ҮАГ-аас 2012 оны санхүүгийн тайлангийн аудитаар Улсын Ерөнхий прокурорын газарт 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Улсын Ерөнхий прокурорын төсвийн багцын 2012 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 85 зөвлөмж өгөгдөж, зөвлөмжийн биелэлт 85 хувьтай байна.

### **Аудитын санал дүгнэлт**

Улсын Ерөнхий прокурорын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлэгдсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудитор санал болгож байна .



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
ПРОКУРОР Д.ДОРЛИГЖАВ ТАНАА

2014.04.25 № 693  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.5-д заасны дагуу Улсын Ерөнхий прокурорын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Улсын Ерөнхий прокурорын газрын удирдлага Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Улсын Ерөнхий прокурорын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

07-451



**YAG**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

### Менежментийн захидал

**Тэргүүлэх ач холбогдол № 2 зүйлс:**

**Асуудал 1** Санхүүгийн тайлагналын талаар

**Асуудал 2** Төсвийн зарцуулалтын талаар

**Асуудал 3** Аудитын дүгнэлтийн талаар

**ҮАГ-ын ажиглалт**

*Санхүүгийн тайланд ажил гүйлгэээ алдаатай илэрхийлсэн байна. Тухайлбал:*

Баянзүрх дүүргийн Прокурорын газар 7.0 сая, Сүхбаатар дүүргийн Прокурорын газар 35.0 сая, Чингэлтэй дүүргийн Прокурорын газар 19.8 сая төгрөгийн үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгөө Засгийн газрын сан дансыг нэмэгдүүлэн буруу илэрхийлсэн,

Нийслэлийн Прокурорын газар үнэ төлбөргүй авсан 150.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үр дүнгийн тайланд орлогоор бүртгээгүй, Хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмжийн 7,894.3 мянган төгрөгийг тайланд тусгаагүй, Үндсэн хөрөнгө данснаас хассаны 1.3 сая төгрөгийн гарзыг бүртгээгүй, Үнэ төлбөргүй хүлээн авсан 61.9 сая төгрөгийн хөрөнгийг Санхүүгийн байдлын тайланд Засгийн газрын сан дансыг нэмэгдүүлэн буруу нэгтгэсэн, Үнэ төлбөргүй хүлээн авсан 84.3 сая төгрөгийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын санхүүжилтээр тайлагнасан байна.

Чингэлтэй дүүргийн Прокурорын газар 6.5 сая, Сүхбаатар дүүргийн Прокурорын газар 9.5 сая төгрөгийн бараа материалын тайлан гаргаагүй байна.

**Эрсдэл**

Мэргэжлийн мэдлэг чадвар дутмагаас байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа доголдож, нягтлан бодох бүртгэл, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалт, зарцуулалтанд тавих дотоод хяналт сулрах

**ҮАГ-ын зөвлөмж**

Нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС-д нийцүүлэн бүрэн хөтөлж, санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан *“Төсөвт байгууллагад мөрдөх НББ-ийн дансны заавар, санхүүгийн тайланг бэлтгэх гаргах аргачлал”* -ын дагуу тайлагнаж, дээрх зөрчлүүдийг цаашид давтан гаргахгүй байх,

Санхүүгийн ажилтнуудын ажлыг дүгнэхдээ санхүүгийн тэнцэл гаргасан чанар байдал, аудитын дүнг харгалзах талаар үр дүнгийн гэрээнд оруулж өгөх,

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хариуг 2014 оны 9 сарын 1-ний дотор ирүүлэх

**Үйлчлүүлэгчийн хариу**

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана.

**ҮАГ-ын ажиглалт**

Баянзүрх дүүргийн Прокурорын газар, Эрүүгийн хэргийн архивын нягтлан бодогч ажилтнуудын өөрсдийнх нь хүсэлтээр 10 ажилтны цалин 27.4 сая төгрөгийг бусдын дансаар дамжуулан олгож, мөн өөрийн дансаар дамжуулан 6.8 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь НББ-ийн тухай хуулийн 20.1.2-т “өөрийн ажил, үүргийн дагуу шууд хяналт тавьдаг албан тушаалын ажлыг хавсран гүйцэтгэх; “ гэж заасныг зөрчжээ. Тухайлбал:

- Баянзүрх дүүргийн Прокурорын газрын нягтлан бодогч Ч.Мядагмаа нь өөрийн картын дансаар дамжуулан 6.8 сая төгрөгийг шилжүүлэн 2 ажилтанд жирэмсэний амралтын тэтгэмжид 4.6 сая төгрөгийг олгон үлдэх 2.2 сая төгрөгийг түүгээрээ зарцуулсан байна.
- Үүнээс өөрийн картын дансанд шилжсэн 1.4 сая төгрөгийг Баянзүрх дүүргийн Прокурорын газрын Санхүүгийн тайланд цалингийн авлагаар тусгажээ.
- Мөн 10 хүний цалинд нийт 27.4 сая төгрөгийг картны хугацаа дууссан, картгүй гэдэг нэрээр бусдын дансаар дамжуулан гүйлгээ хийсэн байна.
- Дээрх картын дансгүйн улмаас өөр ажилтны дансаар дамжуулан гүйлгээ хийсэн гэх Жолооч Б.Сүхбаатарын дансанд 2 ажилтны 1.6 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг шилжүүлсэн, мөн дансгүй гэх Туслах прокурор Ж.Болорпүрэв нь Голомт банкны 9496250452474441 дугаар картыг эзэмшиж байсан хирнээ 2-4 сарын цалингаа Туслах ажилтан Д.Ууганцэцэгийн дансаар дамжуулан авсан байна.
- Эрүүгийн хэргийн архивын нярав Ж.Ганчимэгийн дансаар дамжуулан 2 ажилтны 1.5 сая төгрөгийн цалинг олгожээ.

**Эрсдэл**

Санхүүгийн сахилга, хариуцлага сулрах, цалингийн зардал буруу илэрхийлэгдэх

**ҮАГ-ын зөвлөмж**

Санхүүгийн сахилга хариуцлага алдсан, хууль зөрчсөн тухайн ажил хариуцсан ажилтанд хариуцлага тооцох, ажилтнуудын цалинг бусдын дансаар дамжуулан гүйлгээ хийдэг явдлыг таслан зогсоох,

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хариуг 2014 оны 9 сарын 1-ний дотор ирүүлэх

**Үйлчлүүлэгчийн хариу**

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана.



**ҮАГ-ын ажиглалт**

2013 оны Санхүүгийн тайлангийн аудитаар Дорнод аймгийн Прокурорын газар, Нийслэлийн Прокурорын газруудад хязгаарлалттай санал дүгнэлт өгөгдсөн байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

2013 оны Санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай санал дүгнэлт авсан газруудын холбогдох ажилтнуудад Төрийн аудитын тухай хуулийн 28.1-д заасны дагуу хариуцлага тооцож, хариу ирүүлэх

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хариуг 2014 оны 9 сарын 1-ний дотор ирүүлэх

**Эрсдэл**

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хариуцлага сулрах

**Үйлчлүүлэгчийн хариу**

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана.

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>10,000.00</b>	<b>395,207,396.37</b>
Кассанд байгаа бэлэн мөнгө	10,000.00	-
Төгрөг\ ЖМС	10,000.00	-
Банкинд байгаа бэлэн мөнгө	-	395,207,396.37
Төгрөг	-	395,207,396.37
Төсөвт байгууллын харилцах (Арилжааны банк)	-	384,707,396.37
Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	10,500,000.00
<b>АВЛАГА</b>	<b>177,651,770.41</b>	<b>45,090,065.95</b>
Ажиллагчидтай холбогдсон авлага	4,933,539.08	2,462,921.20
Төлбөртэй үйлчилгээний авлага	149,904,340.00	126,000.00
Бусад авлага	22,813,891.33	42,501,144.75
Байгууллагаас авах авлага	21,600,403.33	41,586,861.75
Гэрэл цахилгааны авлага	352,234.50	-
Түлш халаалтын авлага	5,840,520.00	9,088,413.00
Дотоод албан томилолтын авлага	190,400.00	592,600.00
Шуудан холбооны авлага	30,551.66	-
Бусад зардлын тооцооны авлага	15,186,697.17	31,905,848.75
Хувь хүмүүсээс авах авлага	1,213,488.00	914,283.00
<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>519,437,979.00</b>	<b>12,500,000.00</b>
Бусад урьдчилгаа	519,437,979.00	12,500,000.00
Урьдчилгаа тооцоо	31,937,979.00	-
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	9,400,000.00	-
Томилолтын урьдчилгаа	22,537,979.00	-
Урьдчилж гарсан зардал	487,500,000.00	12,500,000.00
Урьдчилж төлсөн зардал	487,500,000.00	12,500,000.00
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>257,060,604.57</b>	<b>523,431,477.39</b>
Түүхий эд материал	46,731,200.00	95,857,800.00
Тусгай зориулалттай материал	376,200.00	4,275,700.00
Бэлэн бүтээгдэхүүн	46,355,000.00	91,582,100.00
Хангамжийн материал	193,438,174.57	382,470,687.39
Бичиг хэргийн материал	28,697,665.99	43,553,552.51
Аж ахуйн материал	62,676,399.80	129,663,327.88
Сэлбэг хэрэгсэл	22,562,400.00	9,431,400.00
Түлш, шатах тослох материал	24,625,033.48	58,289,974.93
Барилгын засварын материал	1,793,900.00	1,793,900.00
Баглаа боодол	4,217,540.00	601,000.00
Бусад бараа материал	48,865,235.30	139,137,532.07
Мал амьтад	16,706,000.00	22,906,500.00
Бусад	185,230.00	22,196,490.00
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>954,160,353.98</b>	<b>976,228,939.71</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>13,047,957,737.51</b>	<b>19,660,036,875.66</b>
Биет хөрөнгө	11,929,587,837.97	18,796,398,229.68
Барилга, байгууламж, орон сууц	5,416,864,698.60	11,684,605,626.80
Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	8,110,588,544.55	14,585,558,400.55
Барилга, байгууламж орон сууц - Хуримтлагдсан элэгдэл	(2,693,723,845.95)	(2,900,952,773.75)
Авто-тээврийн хэрэгсэл	2,730,068,282.01	2,176,117,578.03
Авто-тээврийн хэрэгсэл анхны өртөг - Анхны өртөг	3,776,464,091.14	3,704,367,691.14
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	(1,046,395,809.13)	(1,528,250,113.11)

Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,155,412,198.45	1,412,070,938.80
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	1,853,535,334.22	2,301,957,646.40
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(698,123,135.77)	(889,886,707.60)
Тавилга, аж ахуйн эд хогшил	811,079,336.40	1,458,808,953.36
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	1,315,388,868.90	2,049,064,469.26
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(504,309,532.50)	(590,255,515.90)
Бусад үндсэн хөрөнгө	158,735,608.50	258,721,900.69
Бусад үндсэн хөрөнгө - Анхны өртөг	174,184,878.81	269,319,362.86
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(18,981,588.31)	(22,084,890.17)
Номын фонд	3,532,318.00	11,487,428.00
Дуусаагүй барилга, байгууламж	1,657,427,714.00	1,806,073,232.00
Биет бус хөрөнгө	1,118,369,899.54	863,638,645.98
Програм хангамж	1,101,645,953.23	846,461,949.71
Програм хангамж - Анхны өртөг	1,149,558,199.01	1,179,262,399.01
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(47,912,245.78)	(332,800,449.30)
Бусад биет бус хөрөнгө	16,723,946.31	17,176,696.27
Бусад биет бус хөрөнгө - Анхны өртөг	16,967,613.00	19,877,613.00
Бусад биет бус хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(243,666.69)	(2,700,916.73)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>14,002,118,091.49</b>	<b>20,636,265,815.37</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>133,715,872.47</b>	<b>840,020,043.09</b>
Өглөг	133,715,872.47	840,020,043.09
Ажилчидтай холбогдсон тооцоо	2,081,247.47	1,918,157.73
Цалингийн өглөг	803,297.98	166,817.00
НДШ-ийн өглөг	768,257.01	1,201,051.73
ХАОАТ-ын өглөг	509,692.48	550,289.00
Бараа үйлчилгээний зардлын тооцоо	3,302,457.51	1,662,877.00
Түлш халаалтын тооцоо	-	1,178,989.00
Цэвэр, бохир усны тооцоо	-	483,888.00
Тээвэр шатахуунын тооцоо	156,000.00	0.00
Бусад зардлын тооцоо	3,146,457.51	-
Бусад өглөг	128,332,167.49	836,439,008.37
Байгууллагад төлөх өглөг	127,132,167.49	836,379,008.37
Хувь хүмүүст төлөх өглөг	1,200,000.00	60,000.00
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>133,715,872.47</b>	<b>840,020,043.09</b>
Засгийн газрын хувь оролцоо	13,868,402,219.02	19,796,245,772.27
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	13,473,789,945.30	12,966,289,945.35
Хуримтлагдсан үр дүн	(1,584,402,454.38)	4,863,704,747.67
Өмнөх үеийн үр дүн	(1,584,402,454.38)	(1,584,402,454.38)
Тайлант үеийн үр дүн	-	6,311,496,651.21
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		136,610,550.84
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,979,014,728.10	1,979,014,728.10
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт		(12,763,648.85)
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>13,868,402,219.02</b>	<b>19,796,245,772.27</b>
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>14,002,118,091.49</b>	<b>20,636,265,815.37</b>

## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

	<b>ӨМНӨХ ОН</b>	<b>ТАЙЛАНТ ОН</b>
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>18,520,983,789.00</b>	<b>24,575,186,539.00</b>
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	18,520,983,789.00	24,575,186,539.00
Улсын төвлөрсөн төсвөөс	18,073,655,566.00	24,316,722,139.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13,211,448,100.00	15,589,232,820.00
Хөрөнгийн	4,862,207,466.00	8,727,489,319.00
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	398,948,040.00	102,405,270.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	398,948,040.00	102,405,270.00
Нийгмийн даатгалын сангаас	48,380,183.00	156,059,130.00
НДС-ийн шилжүүлэг	48,380,183.00	156,059,130.00
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>133,265,664.12</b>	<b>423,510,843.96</b>
Бараа, үйлчилгээний борлуулалт	133,265,664.12	423,510,843.96
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	133,265,664.12	423,510,843.96
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	133,265,664.12	423,510,843.96
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>18,654,249,453.12</b>	<b>24,998,697,382.96</b>
<b>АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ</b>	<b>10,010,430,573.98</b>	<b>11,476,868,816.52</b>
Үндсэн болон нэмэгдэл цалин	8,986,967,464.53	10,253,512,224.92
Үндсэн цалин	8,503,053,462.46	9,731,824,130.31
Гэрээт ажилчдын цалин	104,630,668.00	145,114,718.64
Унаа хоолны хөнгөлөлт	231,695,144.00	234,705,376.97
Бусад нэмэгдлүүд	147,588,190.07	141,867,999.00
Үр дүнгийн урамшуулал	8,107,142.17	11,174,588.00
Унаа, болон бусад нөхөн олговор	139,481,047.90	130,693,411.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	1,023,463,109.45	1,223,356,591.60
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	955,760,422.03	1,111,448,313.37
Тэтгэврийн даатгалын шимтгэл	879,408,020.16	1,022,408,545.39
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	25,272,667.83	33,982,090.31
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	34,147,088.07	42,863,624.26
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	16,932,645.97	12,194,053.41
Эрүүл мэндийн даатгалын хураамж	67,702,687.42	111,908,278.23
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,007,638,736.07</b>	<b>2,846,997,330.91</b>
Бараа үйлчилгээний урсгал зардал	2,605,931,901.07	2,682,049,653.91
Тогтмол зардал	473,965,479.97	510,944,667.87
Гэрэл цахилгаан	79,302,355.54	94,603,055.20
Түлш, халаалт	356,939,372.27	376,883,469.38
Цэвэр, бохир ус	37,723,752.16	39,458,143.29
Бусад бараа үйлчилгээний зардал	2,131,966,421.10	2,171,104,986.04
Бичиг хэргийн зардал	115,084,931.65	185,047,174.00

Тээвэр, шатахуун	249,050,763.50	342,190,659.00
Шуудан, харилцаа холбоо	100,688,287.16	355,115,587.13
Дотоод албан томилолт	222,574,981.59	245,901,691.71
Гадаад албан томилолт	301,143,840.70	256,464,198.20
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	9,438,639.00	41,857,610.00
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	33,089,022.00	13,032,590.00
Сургалт семинарын зардал	-	45,488,157.00
Жижиг эд хогшил худалдан авах	22,753,409.50	123,030,672.00
Жижиг эд хогшил худалдан авах \Багаж хэрэгсэл\	11,004,900.00	3,012,470.00
Жижиг эд хогшил худалдан авах \Тавилга\	11,400,409.50	51,856,184.00
Жижиг эд хогшил худалдан авах \Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс\	-	68,162,018.00
Жижиг эд хогшил худалдан авах \Програм хангамж\	348,100.00	-
Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл	238,477,802.00	189,684,874.00
Төлбөр хураамж, жижиг татварууд	488,829,432.00	58,831,033.40
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	3,693,424.00
ТӨГАУ \ Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс (гадаад) \	-	3,693,424.00
ТӨГАУ \Аудит, зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс (дотоод) \	-	-
ТӨГАУ \Эд хөрөнгийн даатгал\	-	-
Урсгал засвар	251,568,536.00	199,921,731.60
Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал	-	23,318,829.00
Гадаадын зочны зардал	45,934,490.00	45,669,527.00
Бусад зардал	4,727,054.00	-
Аж ахуйн материал худалдан авах зардал	9,269,540.00	-
Газрын төлбөр	1,078,232.00	1,721,633.00
Байрны түрээс	38,257,460.00	38,955,595.00
Хог хаягдал устгах цэвэрлэх зардал	-	1,180,000.00
Хөтөлбөр арга хэмжээний зардал	401,706,835.00	164,947,677.00
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	27,000,000.00	1,353,000.00
Бусад төвлөрсөн арга хэмжээ	2,000,000.00	-
Ой тэмдэглэх арга хэмжээний зардал	25,000,000.00	-
Сургалт, хурал, зөвлөгөөний зардал	-	1,353,000.00
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага, сургуулилт	-	1,353,000.00
Засгийн газрын нөөц хөрөнгө /Орон нутгийн нөөц хөрөнгө/	29,667,500.00	158,052,677.00
Бусад төсөл арга хэмжээ	29,667,500.00	158,052,677.00
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	29,667,500.00	158,052,677.00
Төсвийн хуваарилагдаагүй зардал	345,039,335.00	5,542,000.00
Бусад төсөл арга хэмжээ	345,039,335.00	5,542,000.00
<b>ТУСЛАМЖ, ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>43,511,015.25</b>	<b>378,930,134.89</b>
Засгийн газрын бусад түвшний нэгжүүдэд олгосон	43,511,015.25	378,930,134.89
Төсвийн ерөнхийлөн захирагчдад олгосон санхүүжилт, шилжүүлэг	43,511,015.25	378,930,134.89

Төвлөрүүлэх шилжүүлэг	43,511,015.25	378,930,134.89
<b>НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ</b>	<b>431,320,390.40</b>	<b>445,850,384.27</b>
Нийгмийн даатгалын зардал	37,116,219.00	134,641,892.27
Нийгмийн даатгалын зардал	-	37,494,142.00
Өндөр настны тэтгэвэр	-	37,494,142.00
Тэтгэмжийн даатгалын сан	36,109,058.00	97,147,750.27
Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж	6,473,873.00	14,582,571.00
Жирэмсний, амаржсаны эхийн тэтгэмж	29,635,185.00	82,565,179.27
ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж	1,007,161.00	-
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	1,007,161.00	-
Нийгмийн халамжын зардал	-	27,757,701.00
Жирэмсэн, амаржсан эхийн тэтгэмж	-	27,757,701.00
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	394,204,171.40	239,854,622.00
Нэг удаагийн тэтгэмж	175,949,980.20	126,716,559.00
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	145,067,280.00	109,079,263.00
Нэг удаагийн буцалтгүй тусламж	73,186,911.20	4,058,800.00
Төлбөр, хураамж	-	43,596,169.00
Арилжааны даатгалын хураамж	-	9,967,500.00
Газрын төлбөр	-	-
Тээврийн хэрэгслийн татвар	-	33,628,669.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>13,492,900,715.70</b>	<b>15,148,646,666.59</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>5,161,348,737.42</b>	<b>9,850,050,716.37</b>
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	730,264,213.00	4,500,776,202.00
Хөрөнгийн бусад зардал	4,862,207,466.00	4,954,077,118.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>5,592,471,679.00</b>	<b>9,454,853,320.00</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(5,592,471,679.00)</b>	<b>(9,454,853,320.00)</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(431,122,941.58)</b>	<b>395,197,396.37</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>431,132,941.58</b>	<b>10,000.00</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>10,000.00</b>	<b>395,206,396.37</b>

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>18,479,989,606.00</b>	<b>24,575,186,539.00</b>
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	18,479,989,606.00	24,575,186,539.00
Улсын төвлөрсөн төсвөөс	18,073,655,566.00	24,316,722,139.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13,211,448,100.00	15,589,232,820.00
Хөрөнгийн	4,862,207,466.00	8,727,489,319.00
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	406,334,040.00	102,405,270.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	54,448,040.00	102,405,270.00
Засгийн газрын нөөц хөрөнгө	351,886,000.00	-
Нийгмийн даатгалын сангаас	-	156,059,130.00
НДС-ийн шилжүүлэг	-	156,059,130.00
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>861,273,736.12</b>	<b>836,092,713.59</b>
Бараа, үйлчилгээний борлуулалт	114,445,999.12	836,092,713.59
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	114,445,999.12	836,092,713.59
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	89,546,189.12	27,622,346.59
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24,899,810.00	808,470,367.00
Торгууль, шимтгэл	1,127,437.00	-
Татварын бус бусад орлого	745,700,300.00	-
Хөрөнгийн орлого	745,700,300.00	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>19,341,263,342.12</b>	<b>25,411,279,252.59</b>
<b>АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ</b>	<b>9,997,912,227.54</b>	<b>11,452,862,588.21</b>
Үндсэн болон нэмэгдэл цалин	9,022,961,707.31	10,311,520,020.33
Үндсэн цалин	8,569,403,995.66	9,833,086,876.72
Гэрээт ажилчдын цалин	116,189,208.12	115,730,802.64
Унаа хоолны хөнгөлөлт	195,840,583.00	235,767,741.97
Бусад нэмэгдлүүд	141,527,920.53	126,934,599.00
Үр дүнгийн урамшуулал	4,281,528.63	11,174,588.00
Илүү цагийн нэмэгдэл	40,979,951.00	-
Унаа, болон бусад нөхөн олговор	96,266,440.90	115,760,011.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	974,950,520.23	1,141,342,567.88
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	884,434,552.13	988,496,460.15
Тэтгэврийн даатгалын шимтгэл	765,608,952.79	897,833,805.80
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	54,997,848.42	35,949,532.28
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	36,473,132.37	40,185,702.23
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	27,354,618.55	14,527,419.84
Эрүүл мэндийн даатгалын хураамж	90,515,968.10	152,846,107.73
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,402,091,331.54</b>	<b>4,470,555,120.31</b>
Бараа үйлчилгээний урсгал зардал	3,305,386,402.54	4,365,486,144.31
Тогтмол зардал	454,048,658.17	513,937,339.27
Гэрэл цахилгаан	80,344,918.44	97,146,603.70
Түлш, халаалт	333,012,510.57	374,320,541.28

Цэвэр, бохир ус	40,691,229.16	42,470,194.29
Бусад бараа үйлчилгээний зардал	2,851,337,744.37	3,851,548,805.04
Бичиг хэргийн зардал	109,001,221.58	170,727,836.47
Тээвэр, шатахуун	238,246,654.16	325,042,451.44
Шуудан, харилцаа холбоо	99,873,732.55	350,962,136.39
Дотоод албан томилолт	223,603,728.59	232,840,338.20
Гадаад албан томилолт	279,347,395.70	288,161,468.20
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	6,448,904.00	10,322,880.00
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	32,859,022.00	44,397,450.00
Сургалт семинарын зардал	464,900.00	14,219,297.00
Жижиг эд хогшил худалдан авах	24,510,862.50	122,501,505.00
Жижиг эд хогшил худалдан авах \Багаж хэрэгсэл\	3,368,127.50	3,355,450.00
Жижиг эд хогшил худалдан авах \Тавилга\	21,142,735.00	49,798,259.00
Жижиг эд хогшил худалдан авах \Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл\	-	300,000.00
Жижиг эд хогшил худалдан авах \Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс\	-	68,857,896.00
Жижиг эд хогшил худалдан авах \Програм хангамж\	-	189,900.00
Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл	38,322,131.00	289,256,118.84
Төлбөр хураамж, жижиг татварууд	484,759,906.97	57,981,090.40
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	2,933,424.00
ТӨГАУ \ Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс (гадаад) \	-	2,933,424.00
Урсгал засвар	222,876,377.00	262,293,546.00
Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал	-	22,564,269.00
Гадаадын зочны зардал	19,155,380.00	46,857,007.00
Бусад зардал	3,583,415.00	3,441,400.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,043,532,531.48	1,578,488,056.18
Аж ахуйн материал худалдан авах зардал	19,313,380.00	10,372,781.00
Бараа материал акталсны зардал	4,259,094.84	15,552,116.92
Газрын төлбөр	1,179,107.00	1,663,633.00
Хог хаягдал устгах, цэвэрлэх зардал	-	970,000.00
Хөтөлбөр арга хэмжээний зардал	96,704,929.00	105,068,976.00
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	1,346,500.00	1,899,700.00
Мал аж ахуйн үржлийн зардал	1,311,500.00	741,500.00
Дотоодын уралдаан, тэмцээний зардал	35,000.00	-
Сургалт, хурал, зөвлөгөөний зардал	-	1,158,200.00
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага, сургуулилт	-	1,158,200.00
Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардал	25,000,000.00	-
Засгийн газрын нөөц хөрөнгө /Орон нутгийн нөөц хөрөнгө/	24,498,850.00	97,121,476.00
Бусад төсөл арга хэмжээ	24,498,850.00	97,121,476.00
Баяр наадмын зардал	675,000.00	-
Шагнал, тэтгэмжийн зардал	300,000.00	238,500.00
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	23,523,850.00	96,882,976.00
Төсвийн хуваарилагдаагүй зардал	45,859,579.00	6,047,800.00
Бусад төсөл арга хэмжээ	45,859,579.00	6,047,800.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ҮНДСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ</b>	<b>5,195,906,126.00</b>	<b>2,314,830,730.00</b>



Хөрөнгө оруулалт	5,195,906,126.00	2,314,830,730.00
Дотоод эх үүсвэрээс	5,195,906,126.00	2,314,830,730.00
Төсвийн хөрөнгө оруулалт-барилга байгууламж, төсөл арга хэмжээ	1,661,126,374.00	2,140,740,570.00
Төсвийн хөрөнгө оруулалт тоног төхөөрөмж	2,458,784,482.00	174,090,160.00
Төсвийн хөрөнгө оруулалт их засвар	1,075,995,270.00	-
ТУСЛАМЖ, ШИЛЖҮҮЛЭГ	43,511,015.25	378,930,134.89
Засгийн газрын бусад түвшний нэгжүүдэд олгосон	43,511,015.25	378,930,134.89
Төсвийн ерөнхийлөн захирагчдад олгосон санхүүжилт, шилжүүлэг	43,511,015.25	378,930,134.89
Төвлөрүүлэх шилжүүлэг	43,511,015.25	378,930,134.89
<b>НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ</b>	<b>394,282,894.40</b>	<b>440,488,166.27</b>
Нийгмийн даатгалын зардал	101,775.00	124,905,451.27
Тэтгэмжийн даатгалын сан	101,775.00	124,905,451.27
Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж	101,775.00	19,433,906.00
Жирэмсний, амаржсаны эхийн тэтгэмж	-	105,471,545.27
Нийгмийн халамжын зардал	-	43,609,361.00
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	394,181,119.40	271,973,354.00
Мөнгөн хэлбэрээр	147,174,785.40	109,616,149.00
Нэг удаагийн тэтгэмж	147,174,785.40	109,616,149.00
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	166,626,776.00	146,573,405.00
Нэг удаагийн буцалтгүй тусламж	80,379,558.00	15,783,800.00
Төлбөр, хураамж	-	43,609,361.00
Арилжааны даатгалын хураамж	-	9,967,500.00
Тээврийн хэрэгслийн татвар	-	33,641,861.00
<b>БУСАД ЗАРДАЛ</b>	<b>39,939,460.00</b>	<b>38,361,835.00</b>
Бусдын өмчийг ашигласны зардал	39,939,460.00	38,333,595.00
Байрны түрээс	39,939,460.00	38,333,595.00
Бусад зардал ба алдагдал	-	28,240.00
Найдваргүй авлагын алдагдал	-	28,240.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>19,073,643,054.73</b>	<b>19,096,028,574.68</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>267,620,287.39</b>	<b>6,315,250,677.91</b>
Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	430,000.00	2,460,000.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>430,000.00</b>	<b>2,460,000.00</b>
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	38,586,382.31	3,413,897.56
Үнэ төлбөргүй гарсан зардал	-	2,800,129.14
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>38,586,382.31</b>	<b>6,214,026.70</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>229,463,905.08</b>	<b>6,311,496,651.21</b>

## АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

*/төгрөгөөр/*

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2012 оны 1-р сарын 1- ээрх үлдэгдэл				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
Тайлант үеийн үр дүн				
<b>2013 оны 1-р сарын 1- ээрх үлдэгдэл</b>	<b>13,473,789,945.30</b>	<b>1,979,014,728.10</b>	<b>(1,584,402,454.38)</b>	<b>13,868,402,219.02</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(136,610,550.84)	136,610,550.84
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,473,789,945.30	1,979,014,728.10	(1,447,791,903.54)	14,005,012,769.86
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(507,499,999.95)	(12,763,648.85)	-	(507,499,999.95)
Тайлант үеийн үр дүн	-	-	6,311,496,651.21	6,311,496,651.21
<b>2013 оны 12-р сарын 31- ээрх үлдэгдэл</b>	<b>12,966,289,945.35</b>	<b>1,966,251,079.25</b>	<b>4,863,704,747.67</b>	<b>19,796,245,772.27</b>

## АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ДҮН	ХУВЬ
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,326,737,700.00	23,676,244,988.11	(2,650,492,711.89)	89.93
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	26,326,737,700.00	23,676,244,988.11	(2,650,492,711.89)	89.93
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	16,205,537,700.00	15,209,832,685.11	(995,705,014.89)	93.86
Бараа, үйлчилгээний зардал	15,763,388,000.00	14,894,986,269.11	(868,401,730.89)	94.49
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,497,078,800.00	10,213,918,342.92	(283,160,457.08)	97.30
Үндсэн цалин	9,802,919,800.00	9,719,976,858.31	(82,942,941.69)	99.15
Гэрээт ажилчдын цалин	177,437,900.00	128,542,696.64	(48,895,203.36)	72.44
Унаа хоолны хөнгөлөлт	516,721,100.00	365,398,787.97	(151,322,312.03)	70.71
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,135,002,000.00	1,215,156,204.87	80,154,204.87	107.06
Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэл	930,471,500.00	1,104,717,746.64	174,246,246.64	118.73
Тэтгэврийн даатгал	733,324,200.00	1,015,677,978.66	282,353,778.66	138.50
Тэтгэмжийн даатгал	78,854,900.00	33,982,090.31	(44,872,809.69)	43.09
ҮОМШЕ ний даатгал	98,573,300.00	42,863,624.26	(55,709,675.74)	43.48
Ажилгүйдлийн даатгал	19,719,100.00	12,194,053.41	(7,525,046.59)	61.84
Эрүүл мэндийн даатгалын хураамж	204,530,500.00	110,438,458.23	(94,092,041.77)	54.00
Байгууллага төлөх ЭМД ийн хураамж	204,530,500.00	110,438,458.23	(94,092,041.77)	54.00
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	4,131,307,200.00	3,465,911,721.32	(665,395,478.68)	83.89
Тогтмол зардал	585,450,300.00	510,944,667.87	(74,505,632.13)	87.27
Гэрэл цахилгаан	72,929,000.00	94,603,055.20	21,674,055.20	129.72
Түлш, халаалт	464,875,600.00	376,883,469.38	(87,992,130.62)	81.07
Цэвэр, бохир ус	47,645,700.00	39,458,143.29	(8,187,556.71)	82.82
Бараа, үйлчилгээний бусад зардал	3,545,856,900.00	2,954,967,053.45	(590,889,846.55)	83.34
Бичиг хэрэг	308,241,200.00	183,028,774.00	(125,212,426.00)	59.38
Тээвэр (шатахуун)	295,729,700.00	341,974,259.00	46,244,559.00	115.64
Шуудан холбоо	422,295,800.00	355,115,587.13	(67,180,212.87)	84.09
Дотоод албан томилолт	305,326,500.00	245,459,314.12	(59,867,185.88)	80.39
Гадаад томилолт /арга хэмжээ/	313,065,100.00	256,464,198.20	(56,600,901.80)	81.92
Ном хэвлэл авах	12,791,800.00	39,919,610.00	27,127,810.00	312.07
Эд хогшил худалдан авах	720,002,400.00	724,039,447.60	4,037,047.60	100.56
Тавилга	678,000,000.00	648,934,302.00	(29,065,698.00)	95.71
Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс	42,002,400.00	75,105,145.60	33,102,745.60	178.81
Нормын хувцас зөөлөн эдлэл	406,823,400.00	189,820,874.00	(217,002,526.00)	46.66
Урсгал засвар	159,502,400.00	219,069,337.00	59,566,937.00	137.35
Төлбөр хураамж болон бусад зардал	15,700,000.00	58,831,033.40	43,131,033.40	374.72
Гадаад зочны зардал	40,732,300.00	45,669,527.00	4,937,227.00	112.12
Биеийн тамирын уралдаан тэмцээн	6,000,000.00	23,318,829.00	17,318,829.00	388.65
Байрны түрээсийн зардал	82,473,000.00	38,955,595.00	(43,517,405.00)	47.23

Гэмт хэргээс сэргийлэх арга хэмжээний зардал	247,459,300.00	163,150,477.00	(84,308,823.00)	65.93
Сургалт, хурал, зөвлөгөөний зардал	187,874,000.00	57,116,767.00	(130,757,233.00)	30.40
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага, сургуулилт	54,570,000.00	12,118,610.00	(42,451,390.00)	22.21
Сургалт, семинар зохион байгуулах зардал	133,304,000.00	44,998,157.00	(88,305,843.00)	33.76
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр хураамж	20,160,000.00	11,853,424.00	(8,306,576.00)	58.80
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс (гадаад)	12,000,000.00	3,693,424.00	(8,306,576.00)	30.78
Тээврийн хэрэгслийн даатгал	8,160,000.00	8,160,000.00	-	100.00
Хог хаягдал устгах, цэвэрлэх	1,680,000.00	1,180,000.00	(500,000.00)	70.24
Татаас ба урсгал шилжүүлэг	442,149,700.00	314,846,416.00	(127,303,284.00)	71.21
Ерх гэрт олгох шилжүүлэг	418,596,300.00	277,688,614.00	(140,907,686.00)	66.34
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	238,379,100.00	131,115,209.00	(107,263,891.00)	55.00
Ажил олгогчоос олгох тэтгэмж, нэг удаагийн урамшуулал, дэмжлэг	180,217,200.00	146,573,405.00	(33,643,795.00)	81.33
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	180,217,200.00	146,573,405.00	(33,643,795.00)	81.33
Төлбөр, хураамж	23,553,400.00	37,157,802.00	13,604,402.00	157.76
Арилжааны даатгалын хураамж	9,520,000.00	9,967,500.00	447,500.00	104.70
Амь даатгал	9,520,000.00	9,967,500.00	447,500.00	104.70
Газрын төлбөр-2	5,873,400.00	1,721,633.00	(4,151,767.00)	29.31
Тээврийн хэрэгслийн татвар	8,160,000.00	25,468,669.00	17,308,669.00	312.12
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>10,121,200,000.00</b>	<b>8,466,412,303.00</b>	<b>(1,654,787,697.00)</b>	<b>83.65</b>
1. Дотоод хөрөнгө оруулалт	8,671,200,000.00	7,028,216,962.00	(1,642,983,038.00)	81.05
Хөрөнгө оруулалт :Төсвийн хөрөнгөөр санхүүжих	8,112,200,000.00	6,742,258,532.00	(1,369,941,468.00)	83.11
Тоног төхөөрөмж : Төсвийн хөрөнгөөр санхүүжих	559,000,000.00	285,958,430.00	(273,041,570.00)	51.16
4. Хөрөнгийн шилжүүлэг	1,450,000,000.00	1,438,195,341.00	(11,804,659.00)	99.19
Төсөвт газрын их засвар	1,450,000,000.00	1,438,195,341.00	(11,804,659.00)	99.19
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>26,326,737,700.00</b>	<b>23,676,734,988.11</b>		
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	20,000.00		
Төсвөөс санхүүжих	26,326,737,700.00	23,676,714,988.11		
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	10,000.00		
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	384,707,396.37		